



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/06/НА-СТА-ОНӨ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баруун-Урт 2023 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512127 Цахим хаяг: munkhbambarb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	13
5.1 Зөвлөмж	13
1. Тээвэр, шатахууны зардалтай холбоотой асуудал	13
2. Үйл ажиллагаатай холбоотой асуудал	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Х.БААТАРСҮХ ТАНАА

2023.03.22 № 151
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Барилга, хот байгуулалтын яам “Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сан”-ийн буцалтгүй тусламжийг Азийн хөгжлийн банкны захиран зарцуулах эрхийн дагуу “Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн 9206-МОН төслийг хэрэгжүүлсэн

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн ИТХ-н 2021 оны 10 дугаар тогтоолоор “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах” журам батлуулж, тариф тогтоосон байна.

Бусад асуудлын хэсэг

Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 09/06 дугаар тогтоолоор “Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан боловч гүйцэтгэл, үр дүнг нь дүгнээгүй байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгдэ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	178,927,715.36	201,838,903.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,329,766.26	54,062,625.65
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,329,766.26	54,062,625.65
31210	Төгрөг	18,329,766.26	54,062,625.65
31213	Арилжааны банк дахь харилцах	18,329,766.26	54,062,625.65
33	АВЛАГА	40,155,478.92	8,737,405.93
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	34,367.71	7,603,145.93
33500	Бусад авлага	40,121,111.21	1,134,260.00
33510	Байгууллагаас авах авлага	40,101,055.21	1,134,260.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	20,056.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	1,543,311.60	10,531,504.52
34600	Урьдчилж гарсан зардал	1,543,311.60	10,531,504.52
35	БАРАА МАТЕРИАЛ	118,899,158.58	128,507,367.20
35400	Хангамжийн материал	118,899,158.58	128,507,367.20
35420	Аж ахуйн материал	104,976,622.23	110,700,239.94
35430	Сэлбэг хэрэгсэл	13,922,536.35	17,207,127.26
35470	Бусад хангамжийн материал	0.00	600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,342,262,857.25	6,407,282,920.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,342,262,857.25	6,407,282,920.95
39200	Биет хөрөнгө	7,175,893,857.25	6,239,121,920.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,322,625,248.99	5,344,625,248.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,705,604,274.81	-2,272,927,427.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	458,168,300.00	799,068,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-316,237,605.56	-338,116,563.89
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	39,337,397.04	68,337,397.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,160,542.93	-30,174,397.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,932,105.91	6,850,405.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,533,132.96	-5,934,597.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,313,732,401.53	7,316,732,401.53
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,914,366,039.96	-4,649,338,845.50
39300	Биет бус хөрөнгө	166,369,000.00	168,161,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	166,369,000.00	168,161,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,521,190,572.61	6,609,121,824.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,925,572,762.00	7,027,596,898.40
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,925,572,762.00	7,027,596,898.40
41300	Өглөг	25,420,488.06	23,637,389.00
41360	Бусад өглөг	25,420,488.06	23,637,389.00
41361	Байгууллагад төлөх өглөг	10,681,000.00	14,681,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	2,419,620.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	6,612,193.35	187,000.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	8,127,294.71	6,349,769.00
41400	Урьдчилж орсон орлого	7,900,152,273.94	7,003,959,509.40
41440	Бусад урьдчилж орсон орлого	7,900,152,273.94	7,003,959,509.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-404,382,189.39	-418,475,074.15
51	Засгийн газрын хувь оролцоо	-404,382,189.39	-418,475,074.15
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,332,924,228.00	4,334,716,228.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,332,924,228.00	4,334,716,228.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-9,679,544,749.72	-9,695,429,634.48
51210	Өмнөх үеийн үр дүн	-9,637,435,337.85	-9,671,431,704.73
51220	Тайлант үеийн үр дүн	-42,109,411.87	-23,997,929.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,942,238,332.33	4,942,238,332.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,521,190,572.61	6,609,121,824.25

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,392,026,130.19	2,369,475,739.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,392,026,130.19	2,369,475,739.35
120	Нийтлэг татварын бус орлого	2,392,026,130.19	2,369,475,739.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,951,587,594.92	2,082,094,039.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	711,661,472.82	838,268,440.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,239,926,122.10	1,243,825,599.04
120005	Түрээсийн орлого	4,006,818.18	1,636,363.63
120009	Бусад орлого	409,017,592.54	180,409,692.14
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	27,414,124.55	105,335,644.54
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,434,135,542.06	2,393,473,669.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,434,135,542.06	2,393,473,669.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,434,135,542.06	2,393,473,669.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,106,223,131.49	1,061,801,732.80
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	955,380,728.86	958,232,847.12
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	124,497,230.82	91,305,866.28
210813	Бусад зардал /ТӨҮГ/	26,345,171.81	12,263,019.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,327,912,410.57	1,331,671,936.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,327,912,410.57	1,331,671,936.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-42,109,411.87	-23,997,929.75
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-42,109,411.87	-23,997,929.75

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,332,924,228.00	4,942,238,332.33	-9,600,064,465.68	-324,901,905.35
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-37,370,872.17	-37,370,872.17
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,332,924,228.00	4,942,238,332.33	-9,637,435,337.85	-362,272,777.52
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-42,109,411.87	-42,109,411.87
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,332,924,228.00	4,942,238,332.33	-9,679,544,749.72	-404,382,189.39
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,332,924,228.00	4,942,238,332.33	-9,679,544,749.72	-404,382,189.39
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	8,113,044.99	8,113,044.99
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,332,924,228.00	4,942,238,332.33	-9,671,431,704.73	-396,269,144.40
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	1,792,000.00	0.00	0.00	1,792,000.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-23,997,929.75	-23,997,929.75
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,334,716,228.00	4,942,238,332.33	-9,695,429,634.48	-418,475,074.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,153,279,506.40	1,195,395,607.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,153,279,506.40	1,195,395,607.56
120	Нийтлэг татварын бус орлого	1,153,279,506.40	1,195,395,607.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	711,661,472.82	838,268,440.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	711,661,472.82	838,268,440.00
120009	Бусад орлого	412,150,596.58	240,104,218.56
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	29,467,437.00	117,022,949.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,138,494,272.45	1,102,353,625.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,138,494,272.45	1,102,353,625.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,138,494,272.45	1,102,353,625.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	311,164,268.61	349,769,000.75
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	311,164,268.61	349,769,000.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,875,000.00	109,118,192.42
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	100,875,000.00	109,118,192.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,204,530.47	18,971,954.95
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	16,204,530.47	18,971,954.95
2104	Хангамж, бараа материалын зардал	401,774,500.12	405,999,136.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	167,338,196.80	164,545,015.00

210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	234,436,303.32	241,454,121.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	308,475,973.25	218,495,341.46
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	42,878,975.54	32,526,487.97
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	265,596,997.71	185,968,853.49
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,785,233.95	93,041,981.98
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	600,000.43	40,143.21
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	600,000.43	40,143.21
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,243,900.43	57,349,265.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,243,900.43	57,349,265.80
2200	Дотоод эх үүсвэрээр	16,243,900.43	57,349,265.80
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	15,643,900.00	54,874,380.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	600,000.43	2,474,885.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-15,643,900.00	-57,309,122.59
14	Бусад эх үүсвэр	60,000.00	154,436.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	60,000.00	154,436.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	60,000.00	154,436.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	60,000.00	154,436.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-858,666.05	35,732,859.39
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,188,432.31	18,329,766.26
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,329,766.26	54,062,625.65

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	2	3	5	6
1	Бараа бүтээгдэхүүн борлуулалтын орлого	мян.төг	30,000.00	105,290.20
	Ажил үйлчилгээ борлуулалтын орлого	мян.төг		45.50
	Түрээсийн орлого	мян.төг	1,636.36	1,636.40
	Санхүүжилтийн орлого	мян.төг	749,470.00	838,268.40
	Бусад орлого	мян.төг	1,236,399.57	1,424,235.30
	Нийт орлого	мян.төг	2,017,505.93	2,369,475.80
	Үүнээс: Цэвэр борлуулалт үйл ажиллагааны бус орлого	мян.төг	1,236,399.57	1,243,825.60
2	Нийт зардал	мян.төг	2,077,382.41	2,393,473.70
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	1,506,374.91	1,422,977.80
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	(59,876.48)	(23,997.90)
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(59,876.48)	(23,997.90)
5	Орон нутгийн өмчийн ноогдол ашиг			
6	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	63	56
7	Нийт цалингийн сан	мян.төг	451,000.00	426,523.90
8	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	596.56	634.71

9	Борлуулалтын /1 төгрөгт ноогдох зардал өссөн буурсан/			
10	Хөрөнгө оруулалт			
11	Нийт авлага	мян.төг	-	8,737.40
	Үүнээс: найдвартай	мян.төг	-	8,737.40
	найдваргүй	мян.төг		
12	Нийт өглөг	мян.төг	6,699,854.19	7,027,596.90
	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	мян.төг	6,699,854.19	7,027,596.90
	Урт хугацаат өр төлбөр			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн зорилго нь хог хаягдлын менежментийг сайжруулж, Баруун-Урт сумын иргэдийг эрүүл аюулгүй, цэвэр орчинд ая тухтай ажиллаж, амьдрах боломж нөхцөлийг бүрүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, засвар арчлалт гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд автозам, замын байгууламжийг засвар арчлалт статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ статустайгаар төрийн 100 хувийн өмчлөлтэй, Баруун-Урт суманд харьяалагдаж, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн эд аж ахуйн ашиглалт, хамгаалалтыг хариуцаж, түүнд учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх
- Орчны ариун цэврийг сахиулж, эрүүл орчин бий болгож, хог хаягдлыг ил задгай хаяхаас сэргийлэх
- Өвлийн улиралд аймгийн төвийн гудамж талбай, замын цас, мөсний цэвэрлэгээг тогтмол хийх
- Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах болон түүхий эдийн эх үүсвэр болгон дахин ашиглах
- Хог хаягдлын төлбөрийг иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс хураан авч, өөрийн үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулах
- Золбин муур, нохойн устгал хийх
- Ландфиллийн арга технологиор тохижуулсан аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгийн эмх цэгцийг алдагдуулалгүй хогийг заасан цэгүүдэд хаях, бусад иргэн байгууллагаас тээвэрлэн ирсэн хог хаягдалд хяналт тавьж, харуул манаачийг ажиллуулах
- Мал, туслах аж ахуйн амьтдыг хориглосон цэгт оруулахгүй, ногоон байгууламж устгах, хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх
- Гэр хороолол, нийтийн эзэмшлийн зам талбай, явган замын эвдрэлийг засварлах

- Хөл газрын ургамлын харшлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, цэвэр цэмцгэр орчин бүрдүүлэх хотын тохижилтод өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор шарилжийг тухай бүр нь тогтмол устгах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 912,068.8 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,329.8	54,062.6	35,732.8
Авлага	40,155.5	8,737.4	-31,418.1
Урьдчилж төлсөн зардал	1,543.3	10,531.5	8,988.2
Бараа материал	118,899.1	128,507.4	9,608.3

<i>Үндсэн хөрөнгө</i>	7,175,893.9	6,239,121.9	-936,772.0
<i>Биет бус хөрөнгө</i>	166,369.0	168,161.0	1,792.0
<i>Нийт хөрөнгө</i>	7,521,190.6	6,609,121.8	-912,068.8
<i>Өр төлбөр</i>	7,925,572.8	7,027,596.9	-897,975.9
<i>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</i>	-404,382.2	-418,475.1	-14,092.9
<i>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</i>	7,521,190.6	6,609,121.8	-912,068.8

Харилцах дансны үлдэгдэл 54,062.6 мянган төгрөг болж 35,732.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын үлдэгдэлд 8,737.4 мянган төгрөг болж 31,418.1 мянган төгрөгөөр буурсан нь Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангаас “Хог хаягдлын менежментийг сайжруулах” төслийн хүрээнд хийгдсэн ажлын үлдэгдэл санхүүжилтийн үлдэгдэл авлагыг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үнэ төлбөргүй 343,100.0 мянга, худалдан авсан 51,800.0 мянга, нийт 394,900.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 4,081.7 мянган төгрөгийн хөрөнгийг Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 383 дугаар албан бичгийн дагуу акталж, хөрөнгө элэгдлийн зардлаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 7,027,596.9 мянган төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 897,975.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудад үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн бөгөөд тус хөрөнгө элэгдлийн зардлаараа буурсан нь нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 09/06 дугаар тогтоолоор “Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,017,505.93 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,077,382.4 мянган төгрөгөөр, 59,876.5 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 2,369,475.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,393,473.7 мянган төгрөгийн зардал гарган, 23,997.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,017,505.9 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,369,475.8 мянган төгрөг буюу 15 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,077,382.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 2,393,473.7 төгрөг буюу 13 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

Нийт орлого зардал давсан нь БХБЯ-ны хэрэгжүүлж буй АХБ-ны захиран зарцуулах эрхтэй Ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжих “Аймгийн төвийн хатуу хог хаягдлын менежмент” 9206-МОН төслийн тус онд хэрэгжсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 23,997.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс алдагдлаас 35,878.6 мянган төгрөгөөр буурсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өр төлбөр, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 2,393,472.7 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 47,869.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 33,508.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд зардлууд 153.1 мянган төгрөгөөр өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	300.0	1	300.0	100
Албан шаардлага	1	18,457.7	1	18,457.7	100
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	4	18,757.7	4	18,757.7	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 зөрчил² илэрснээс алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

1. Тээвэр, шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй нь Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, сангийн сайдын 2022.12.23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 4.2 дахь "Алба ажлын автомашин нь Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын шаардлагыг хангасан байна." заалт, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын 8.4.3, 11.1 дэх заалттай нийцэхгүй байна. Албан ажлын автомашинуудад GPS суурилуулаагүй нь шатахууны зардалд хэмнэлт бий болохгүй байх сөрөг үр дагавартай байна.

Өгсөн зөвлөмж:

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Албан ажлын автомашинуудад MNS 4598 стандартад заасан мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулж, жолоочийн тооцооны хуудаст автомашины явсан маршрутыг жолоочоор GPS-ийн мэдээлэлд үндэслэн дэлгэрэнгүй бичүүлж, хяналт тавьж, шатахууны зардалд хэмнэлт бий болгож ажиллах.

2. Үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 /Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно./ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 /үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;/ дахь заалтыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Албан ажлын автомашинд GPS суурилуулаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-